



# МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

“Өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцуулах ажлыг зохицуулах, зохион байгуулах, суралцах хүмүүсийн талаар дүгнэлт гаргах комисс”-ын 2000 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дашдоржийн Наранбаатарыг АНУ-ын Пүрдүгийн Их сургуулийн магистрантурт, Зундуйн Гантулгыг АНУ-ын Колорадогийн Их сургуулийн магистрантурт тус тус 2 жилийн хугацаагаар 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.
2. АНУ-ын Хойд Кароланагийн Их сургуулийн аспирантурт суралцаж буй Агваанлуvsангийн Ундраа, ХБНГУ-ын Гийзен хотын Их сургуулийн аспирантурт суралцаж буй Цэндсүрэнгийн Эрдэнэбилэг нарын суралцах хугацааг тус бүр нэг жилээр, АНУ-ын Колорадогийн Их сургуульд суралцаж буй Төмөрбаатарын Наранчимэг, Содномдоржийн Ууганбаяр нарын суралцах хугацааг тус бүр нэг семестрээр сунгасугай.
3. ОХУ-ын Москва хотын Эдийн засаг, Статистик, Мэдээлэл зүйн Улсын их сургуулийн аспирантурт суралцаж буй Батсүхийн Батмөнх, Казахстан улсын Алма-Ата хотын Эмч нарын мэргэжил дээшлүүлэх институтийн аспирантурт суралцаж буй Ануар Нота нарын хамгаалалтын зардлыг, Украин улсын Львов хотын Политехникийн Их сургуулийн аспирантурт суралцаж буй Даланбаярын Болормаагийн 1 жилийн сургалтын төлбөрийг зээлээр олгосугай.
4. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

САЙД  А.БАТТӨР